

“МОНОС ХҮНС” ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ БУС ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Огноо: 2024-09-09

Хурал хийсэн газар: meeting.monosfoods.mn/shareholder/meeting/8/ вэб хуудсаар нэвтрэн цахимаар хуралдав.

Эхэлсэн цаг: 14:00

Дууссан цаг: 15:50

Бичлэг: <https://www.facebook.com/MonosFoods/videos/1727232824751688>

Хурлыг зарласан: Монос Хүнс ХК

Хурлын зохион байгуулагч бүрэлдэхүүн:

Хурлын дарга: ТУЗ-ийн дарга Х.Ананд

Хурал зохион байгуулах комиссын дарга: Гүйцэтгэх захирал А.Отгондарь

Тооллогын комиссын дарга: Санхүүгийн менежер Э.Амарболд

Тооллогын комиссын гишүүд: Санхүүгийн шинжээч П.Энхбаяр

Бүтээгдэхүүний менежер Ц.Дөлгөөнмайдар

Тэмдэглэл хөтлөсөн: ТУЗ-ийн нарийн бичгийн дарга Н.Цагаанхүү

Хэлэлцэх асуудал:

1. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
2. Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсөвт тодотгол хийх

Хурлын дарга Х.Ананд: Монос Хүнс ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг нээж, хурлын дэг болон 2024 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн 24/10 дугаартай “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах тухай” тогтоолыг уншиж хурал хуралдах өдөр, цаг, цахим хэлбэр, хурлын зарыг түгээсэн сувгуудыг мэдээлж, тооллогын комиссын бүрэлдэхүүнийг уншиж танилцуулаад Тооллогын комиссын дарга Э.Амарболдыг индэрт урив.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Нийт хувьцаа эзэмшигчиддээ энэ өдрийн мэндийг хүргэе. Тооллогын комиссын тогтоолыг танилцуулж байна. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.1, 68.4 дахь хэсгийг тус тус үндэслэн Компанийн саналын эрх бүхий энгийн нийт 408,850,428 пирхэг хувьцаанаас саналын эрхтэй 341,729,880 пирхэг хувьцаа буюу 83.58%-ийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчид хуралд урьдчилан бүртгүүлж, хуралд нэвтрэх нэр, нууц үгийг авч, хурлын үеэр зайнаас холбогдсон байх тул хурлыг хүчин төгөлдөрт тооцсугай. Тооллогын комисс. Хурлын ирцийг системээр одоо ч бүртгэж байгаа гэдгийг хувьцаа эзэмшигчдэдээ хэлье.

Хэлэлцэх асуудал 1: ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох

Хурлын дарга Х.Ананд: Хурлын дэгийн дагуу “Монос Хүнс” ХК-ийн ТУЗ-ийн ердийн гишүүнд ажиллаж байсан Л.Хүрэлбаатар, Х.Ананд, Х.Солонго, Ц.Цэцэгбадам, А.Отгондарь, Ч.Баттогтох нар улиран сонгогдохоор хүсэлтээ ирүүлсэн, шинээр С.Баянмөнх нэр дэвшиж байгаа, ердийн гишүүнд нэр дэвшиж байгаа эдгээр 7 хүний боловсрол, ажлын туршлага, засаглалын мэдлэгийн талаар тусгасан дэлгэрэнгүй танилцуулгыг уншиж танилцуулав. Танилцуулгыг хавсаргав.

Хурал зохион байгуулах комиссын дарга А.Отгондарь: “Монос хүнс” ХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнд улиран сонгогдохоор нэр дэвшиж байгаа хараат бус гишүүд Б.Гантулга, О.Лхагвасүрэн нарын болон шинээр нэр дэвших хүсэлтээ ирүүлсэн 28 хүнээс ТУЗ-ийн дэргэдэх Цалин урамшуулал нэр дэвшүүлэх хорооны хурлаар хэлэлцэн сонгон шалгаруулж хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцүүлэхээр оруулсан Ө.Оргил-Эрдэнэ, М.Болод, О.Баярмагнай, М.Сарандаваа, Н.Улаанхүү, Д.Отгонбат, Г.Золжаргал, Д.Гэрэлт-Од, Б.Гансүх, Д.Энхжаргал, Б.Гантулга зэрэг 11 нэр дэвшигчдийн боловсрол, ажлын туршлага, ТУЗ-д ажиллаж байсан туршлага зэргийг тусгасан дэлгэрэнгүй танилцуулгыг танилцуулав. Танилцуулгыг тэмдэглэлд хавсаргав.

Хэлэлцэх асуудал 2: Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсөвт тодотгол хийх

Хурлын дарга Х.Ананд: “Монос Хүнс” ХК-ийн ТУЗ-ийн 2024 оны төсөвт оруулж байгаа тодотголыг танилцууллаа. Компанийн ТУЗ-өөс жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалсан шийдвэр гаргах, ТУЗ-ийн гишүүдийн ачааллыг бууруулах, компанийн засаглалыг сайжруулах зорилгоор 2024

оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар компанийн дүрмийн 7 дугаар зүйлийн 7.2-д ТУЗ-ийн хараат бус гишүүдийн тоог 2-оор нэмж 11 болгох заалтыг тусган дүрмийн өөрчлөлтийг батлуулсан. Үүний хэрэгжилтийг хангах үүднээс ТУЗХ-аас хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулж, нийт 11 гишүүнийг кумулятив аргаар сонгон, 2024 оны 04 дүгээр сарын 20-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 02 тоот тогтоолоор батласан ТУЗ-ийн 9 гишүүний цалинг 11 гишүүний цалин болгон тодотгол өөрчлөлт оруулсныг танилцуулав. Танилцуулгыг хавсаргав.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Хурлын дэгийн дагуу цахимаар санал өгөх зааврыг танилцуулав. 1-р асуудалд ТУЗ гишүүнд нэр дэвшигчдийн санал өгөх хэсэг байгаа кумулятив аргын талаар тайлбарлав. 2-р асуудалд ТУЗ-ийн 2024 оны төсвийн тодотголыг батлах хэсэгт “зөвшөөрсөн”, “тагталзсан”, “түдгэлзсэн” гэсэн хариултуудаас сонголтоо хийж чагтална. Танилцуулгыг хавсаргав.

Хурлын дарга Х.Ананд: Хурлын дэгийн дагуу асуулт хариултын цаг эхлэж байна.

Цахимаар хандсан хувьцаа эзэмшигчдээс асуулт ирэх хугацаанд Гүйцэтгэх захирал А.Отгондарь шинээр гарч байгаа бүтээгдэхүүний талаар мэдээлэл өгөв.

Хувьцаа эзэмшигч У.Оюунтуяа: Сайн байна уу, яагаад ТУЗ-ийн гишүүдийн тоог нэмсэн бэ?

Хурлын дарга Х.Ананд: ТУЗ-ийн ердийн гишүүдийн тоо хэвээрээ байгаа, хуучин хараат бус гишүүдийн тоо бага байсан, бид компанийн засаглалыг сайжруулах, жижиг хувьцаа эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс хараат бус гишүүдийн тоог нэмсэн. Мөн ТУЗ-ийн дэргэд 4 хороо байгаа, хороодыг хараат бус гишүүдээр даргалуулж, хорооны гишүүдыг голдуу хараат бус гишүүдээр бүрдүүлдэг учир хараат бус гишүүдийн ачааллыг бууруулах, компанийн засаглалыг сайжруулах зарчмыг хангах, ТУЗ, хороодын үйл ажиллагааг нээлттэй болгох үүднээс тоог нэмж байна.

Хувьцаа эзэмшигч Б.Дуламсүрэн: Киргизийн экспорт ямархуу борлуулалттай байгаа бэ?

Хурлын дарга Х.Ананд: 2024 оны 1 сард эхний 1 машин бараа, саяхан 2 дахь машин бүтээгдэхүүн барааг Киргиз улс руу явуулсан. Хавар компанийн нээлтээ хийсэн, 200 гаруй эмийн сангаар бүтээгдэхүүнээ байршуулсан, цаашид 8 нэрийн бараа болон супермаркетын салбарт бүтээгдэхүүнээ нийлүүлэхээр төлөвлөж байна. Мөн Бишкек хотод Монос группт харьяалагддаг 1 төлөөлөгчийг байнгын ажиллуулж байна, Киргиз улс бол 7 сая иргэнтэй, бид нийт 1000 гаруй эмийн санд болон сүлжээ дэлгүүр, супермаркетын 40%-д нийлүүлэлт хийж бүтээгдэхүүнээ байршуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Хурал зохион байгуулах комиссын дарга А.Отгондарь: Монгол улсад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг олон улсын стандартад нийцүүлэх, эсвэл тухайн улсын стандартыг хангасан байж бид экспортлох боломжтой, тиймээс бид бараа бүтээгдэхүүнээ бүртгүүлэх, энэ стандартад нийцүүлэхээр ажиллаж байна, энэ нь цаг хугацаа их шаарддаг ажил юм байна. Үүнийг Монос фарм, Монос косметикс, Монос хүнс гэсэн 3 үйлдвэр хамтран хангахаар ажиллаж байна. Бараа бүтээгдэхүүнээ амжилттай бүртгүүлсэн, Монос хүнс ХК-д ногдох орлого нь 40 мянга орчим доллар байна. Одоогоор эмийн сувгаар байршуулаад байгаа бүтээгдэхүүнийг хүнсний сувагт нийлүүлэн тээлт хийхээр бид ажиллаж байна.

Хувьцаа эзэмшигч: ТУЗ гишүүнд анкет ирүүлсэн хүмүүсээс ямар шалгуураар нэр дэвшүүлсэн бэ?

Хурал зохион байгуулах комиссын дарга А.Отгондарь: Би та бүхэнд хараат бус гишүүнд нэр дэвшигчдийн анкет мэдээллийг танилцуулсан. 28 хүн анкет мэдээллээ ирүүлсэн, бидэнд хандан хүсэлтээ ирүүлсэн та бүхэнд баярлалаа. Хөрөнгийн зах зээл, үйлдвэрлэлийн салбар, сүүлийн үед нилээн чухал сэдэв болоод байгаа ногоон эдийн засаг, байгаль орчин, нийгэм засаглалын мэдлэг туршлагатай, мөн ТУЗ-ийн засаглалын туршлагатай хүмүүс хандсан нь бидэнд таатай байсан. Нэр дэвшүүлэх хороо эдгээр хүмүүсээс 13 нэр дэвшигчдийг сонгон шалгаруулсан нь Монос хүнс ХК-ийн цаашдын стратегид оруулах хувь нэмэр зэрэг олон шалгуур, мөн үйлдвэрлэлийн компани учир цаашид өсөлт хийнэ, илүү олон дистрибьюшнтэй хамтран ажиллана, олон улсад экспорт хийнэ, засаглалын хувьд сайжирч өсөн дэжинэ зэргийг бодолцож Нэр дэвшүүлэх хорооноос сонголтыг хийж нэр дэвшүүлсэн. Энэ хороог ТУЗ-ийн хараат бус гишүүн Б.Гантулга даргалдаг. Нэр дэвшсэн 13 хүнээс хувьцаа эзэмшигч та бүхэн сонголтоо хийнэ.

Хувьцаа эзэмшигч: Шинэ бүтээгдэхүүн гарч байгаа юу? Төлөвлөгөө бий юу?

Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Бид хамгийн сүүлд сая 8 сард “Уушги цэвэрлэх цэнэг”-ийг худалдаанд гаргаснаар цэнэгийн нэр төрөл нэмэгдэж байгаа. Хувьцаа эзэмшигчдэд үйлдвэрлэлийн өргөжилт тэлэлт, өндөр дүнтэй хөрөнгө оруулалт зэрэг нь нилээн чухал сэдэв байдаг. MFC-2.0 төслийн хүрээнд бид хоосон газар дээр шинэ үйлдвэрээ барьж, тоног төхөөрөмжийн угсралт суурилуулалтын ажил явагдаж, одоо төслөө хаах шатанд орчихсон байна. Шинэ үйлдвэр ашиглалтанд орсноор шинэчилсэн савалгаагаар 3 нэр төрөл нь худалдаанд гарна. Мөн бид оргилуун экосыг үйлдвэр дээрээ савлаж чадахгүй, зах зээлд эрэлт ихтэй ч, тасалдалтай байсныг одоо үйлдвэрлэж худалдаанд гаргана. Халуун савалгаа дээрээ ургамлын цай болон вита С зэрэг шинэ бүтээгдэхүүнийг 2025 онд үйлдвэрлэж худалдаанд гаргахаар төлөвлөөд байна.

Хувьцаа эзэмшигч: Байгаль орчин нийгэм засаглалын чиглэлээр ямар ажлууд хийгдэж байгаа бэ?

Гүйцэтгэх захирал А.Отгондарь: 2022 онд “Green footprint” төслийг байгуулж ISO 14001 байгаль орчны тогтолцооны стандартыг үйл ажиллагаандаа нэвтрүүлэхээр төслийн багаа анх байгуулж байсан. Энэ төслөөс үүдэн бид байгаль орчин, нийгэм, засаглалын чиглэлийн асуудлууд руу илүү анхаарч эхэлсэн байгаа. Анх хувьцаат компани болж үйлдвэрээ ашиглалтанд оруулахдаа саарал усны хэрэглээтэй, цахилгаан эрчим хүчний хэмнэлттэй, байгаль орчинд ээлтэй үйлдвэр ашиглалтанд оруулахаар зорьж оруулсан, дараагийн үйлдвэр MFC-2.0 төсөлдөө энэ бодлогоо үргэлжлүүлэн барьж, байгаль орчин, нийгэм, засаглалын үнэлгээг хийлгэж, хүлэмжийн хийн ялгаруулалтыг багасгахад анхаарсан зэрэгт анхаарч БОНЗ-ын үнэлгээг олон улсын түвшинд хийлгэсэн.

Цаашид хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдэдээ тогтвортой хөгжлийн тайланг тогтмол танилцуулж байх болно. Энэ тайлагналын хүрээнд бид хамтрагч, харилцагч, ажилтан бүртэй хамтран ажиллах шаардлага үүсч байгаа учир хамтран ажлаа тайлагнаж байх болно.

Хувьцаа эзэмшигч Б.Баянмөнх: Та бүхний ажилд амжилт хүсье. Шинэ үйлдвэрт ажиллах хүч ямар байгаа бэ? Үйл ажиллагааны зардал цаашдаа нэмэгдэх үү?

Гүйцэтгэх захирал А.Отгондарь: MFC-2.0 төсөл дээр сүүлийн 2 жил ажиллаж байна. МУ-ын хэмжээнд ажиллах хүчний хомсдол их байгааг та бүхэн мэдэж байгаа. Ялангуяа үйлдвэрлэлийн салбар, инженер техникийн чиглэлийн боловсон хүчин хангалтгүй байна. Хэдий ийм байгаа ч бид шинэ үйлдвэр дээрээ ажиллах ажилтны тогтвор суурьшлыг барих, ажлын нөхцлийг сайжруулахад байнга анхаарч ажиллаж байна. Энэ чиглэлээр жил бүр ажилтны сэтгэл ханамжийг судласан соёлын судалгаа хийх, тав тухтай ресторан, амралтын бүс, иог фитнесс өрөө, хүүхдийн өрөө гэхчилэн ажлуудыг хийхээр төлөвлөж байна. Мөн цалинг өнгөрсөн оноос 25%-аар өсгөсөн. Үйлдвэрлэлээс шалтгаалан тэлэлтийн ажлын байрууд үүсч байгаа ч гэсэн борлуулалтаас үйл ажиллагааны зардлаа бага байлгахад чиглэн ажиллаж ашигт ажиллагааг нэмэх болно.

Хувьцаа эзэмшигч Б.Баянмөнх: Борлуулалтын сүлжээ нь Монос эмийн сангуудаар борлуулагдаж байгаа. Яагаад заавал дахин борлуулалтын өөр хүмүүсийг авч ажиллуулдаг бэ?

Гүйцэтгэх захирал А.Отгондарь: Монос хүнс компани одоогоор 6 мянга орчим цэгээр борлуулалтаа хийдэг. Энэ цэгүүдээ сувгаар ангилахад эмийн суваг гэсэн ангилалд Монос эмийн сан болон бусад эмийн сан ордог. Монос хүнс ХК нь эрүүл мэндийн хүнсний үйлдвэр, бүтээгдэхүүн маань хүнс, гэхдээ эрүүл мэндийг дэмжих бүтээгдэхүүн учир эмч төлөөлөгчид бүтээгдэхүүнээ эмийн сувгаар дамжуулан танилцуулах, борлуулалтыг элсэмгдүүлэхэд анхаарч ажилладаг нь бидний давуу тал болдог. Борлуулалт бол худалдааны төлөөлөгч захиалгаа аваад түгээлтийн хэсэг хүргэж явдаг. Монос эмийн сангийн хувьд цаг хэмнэсэн олон давуу тал байдаг, жишээ нь нэгдсэн ERP систем ашигладаг тул борлуулалтын захиалга, нөөцийн удирдлага, төлбөр тооцоо нэгдсэн системээр явдаг. Гэхдээ эрүүл мэндийн энэ бүтээгдэхүүнийг лангуу дээр зөв байршуулах, бүтээгдэхүүний талаар өндөр мэдлэгтэй байх зэрэг шаардлагатай учраас борлуулалтын ажилтан зайлшгүй хэрэгтэй байдаг. Энэ нь манай үйл ажиллагааны онцлогтой хамааралтай.

Хувьцаа эзэмшигч Б.Отгонбаатар: 2024 оны цэвэр ашгийн төсөөлөл?

Гүйцэтгэх захирал А.Отгондарь: 2024 оны эхний хагас жилийн тайлангаа бид хуулийн хүрээнд тайлагнадаг, саяхан МХБирж цахим талбараар тайлагнасан. 2024 оны цэвэр ашгийг 3.4 тэрбум төгрөг буюу өнгөрсөн оноос бага зэргийн өсөлттэйгээр төлөвлөж байгаа, цаг хугацааны хувьд хөрөнгө оруулалтаа нөхөх хугацаа тул та бүхэн ойлгож хүлээн авна гэж найдаж байна.

Хурлын дарга Х.Ананд: Ингээд өнөөдрийн асуулт хариултын цаг дууссан байна. Санал хураалт эхэлсэн, явагдаж байгаа, дүнг гарахаар танилцуулах болно.
(Компанийн үйл ажиллагаа, MFC 2.0 төслийн бүтээн байгуулалт, бүтээгдэхүүний танилцуулга бүхий реклам бичлэг)

Хурлын дарга Х.Ананд: Санал хураалтын хугацаа дууссан байна. Өнөөдрийн цахим хуралд хөндлөнгөөс хяналт тавихаар Голомт капитал ҮЦК-ы харилцагчийн үйлчилгээний ахлах Б.Эрдэнэцэцэг оролцож байна. Монос хүнс ХК-ийн өнөөдрийн ээлжит бус хурал нийт 14 мянга гаруй хувьцаа эзэмшигч оролцох эрхтэйгээс 4 мянга гаруй хувьцаа эзэмшигчид Голомт капитал ҮЦК-д бүртгэлтэй байдаг юм. Санал хураалтын дүн гарсан байна. Дүнг танилцуулна уу гээд тооллогын комиссын дарга Э.Амарболдыг урья.

Тооллогын комиссын дарга Э.Амарболд: Санал хураалт 15 цаг 30 минутанд хаагдсан. Та бүхэнд тооллогын комиссын тогтоолыг уншиж танилцуулья. Компанийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.3.2, 67.3.8 дахь хэсгийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хуралд оролцсон саналыг тоолж санал хураалтын дүнг нэгтгэснийг үндэслэн **ТОГТООХ НЬ:**

Батлах асуудал 1: “Монос хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох” кумулятив аргаар санал хураасан дүнг танилцуулья. Санал өгсөн хүний хувьцааны тоог ТУЗ-ийн гишүүний тоо буюу 11-ээр үржүүлээд нийт 3,710,114,255 ширхэг саналын эрх санал өгснөөс ТУЗ гишүүдийн саналын тоо болон саналын эрхэд харьцуулсан хувийг дэлгэц дээр харуулж байна.

Ердийн гишүүнд 7 хүн нэр дэвшсэнээс

1. ТУЗ-ийн ердийн гишүүн Х.Ананд – 327,935,985 санал буюу 8.839%
2. ТУЗ-ийн ердийн гишүүн А.Отгондарь – 326,793,225 санал буюу 8.808%
3. ТУЗ-ийн ердийн гишүүн Ч.Баттогтох – 319,300,113 санал буюу 8.606%
4. ТУЗ-ийн ердийн гишүүн Х.Солонго – 312,973,951 санал буюу 8.436%
5. ТУЗ-ийн ердийн гишүүн Л.Хүрэлбаатар – 305,112,486 санал буюу 8.224%
6. ТУЗ-ийн ердийн гишүүн Ц.Цэцэгбадам – 302,787,279 санал буюу 8.161% санал авч улиран

Дараагийн хэсэгт ТУЗ-ийн хараат бус гишүүдийн саналын тоо болон саналын эрхэд харьцуулсан хувийг дэлгэц дээр харуулж байна. Хараат бус гишүүнд нийт 13 хүн дэвшсэнээс

1. ТУЗ-ийн хараат бус гишүүн Г.Золжаргал – 300,454,698 санал буюу 8.098%
2. ТУЗ-ийн хараат бус гишүүн М.Сарандаваа – 300,267,860 санал буюу 8.093%
3. ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Энхжаргал – 299,533,058 санал буюу 8.073%
4. ТУЗ-ийн хараат бус гишүүн Д.Гэрэлт-Од – 296,157,442 санал буюу 7.982%
5. ТУЗ-ийн хараат бус гишүүн Н.Улаанхүү – 288,807,191 санал буюу 7.784%

санал авч шинээр тус тус сонгогдлоо.

Батлах асуудал 2: “Монос хүнс ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2024 оны төсөвт тодотгол хийх” санал хураалтын дүн:

1. Зөвшөөрсөн – 309,217,717 ширхэг буюу 99,99 % ;
2. Татгалзсан – 40,667 ширхэг буюу 0,01 % ;
3. Түдгэлзсэн – байхгүй ;
4. Санал өгөөгүй/хүчингүй хуудас байхгүй

тул Компанийн тухай хуулийн 63.5 дахь хэсэгт зааснаар шийдвэр хүчинтэй.

Хурлын дарга Х.Ананд санал асуулгын дүнд үндэслэн “ТУЗ-ийн гишүүдийг сонгох тухай”, “Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2024 оны төсөвт тодотгол хийх тухай” тогтоолуудыг уншиж танилцуулан шинээр сонгогдсон ТУЗ гишүүдэд амжилт хүсэн хурлын үйл ажиллагаа 15 цаг 50 минутанд дуусав.

Тэмдэглэл хөтөлсөн:

Н.ЦАГААНХҮҮ

Тэмдэглэл хянасан: Хурлын дарга

Х.АНАНД